

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/023/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Монгол Улсын Ерөнхий Аудиторын орлогч Я.Самбууням Утас: 329871 Цахим хаяг: sambuunyamya@audit.gov.mn Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 51-260512 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас:51-261628 Цахим хаяг: bujinkhandj@audit.gov.mn Аудитор: Д.Номингуа Утас:51-261628 Цахим хаяг: nominguad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ,
ХАМГААЛЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.БАЯРСАЙХАН ТАНАА

2025.02.25 № 07/688
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар дараах материаллаг хэмжээний зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

1. Хүүхэд хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр арга хэмжээний зардлаас 197,142.6 мянган төгрөгийг байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн;
2. Батлагдсан төсвөөс нийт 186,083.1 мянган төгрөгийн дэмжлэг, шагнал олгосон;
3. Төсвийн шууд захирагчийн төсвөөс бусад төсөвт байгууллагын нийт 913,329.7 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн;
4. Мөнгөн гүйлгээний тайланд зардлын ангиллыг нийт 387,795.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
5. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээр 22,920.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад байгууллагад ашиглуулсан;

6. Тайлант хугацаанд зарлагын баримтгүй 3,040.0 мянган төгрөгийн, жолоочийн замын хуудасгүй 9,345.2 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан, 51,894.4 мянган төгрөгийн шатахууны тооцоог бодсон акт үйлдээгүй;
7. Өмнөх аудитаар өгсөн 472,706.2 мянган төгрөгийн 2 шийдвэрийг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5, 20.2.6 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-ын холбогдох заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “ангилал”, “нийцсэн ба зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Хүүхдийг зуслангийн хөгжлийн хөтөлбөрт тэгш хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг 2024 онд бүсчлэн зохион байгуулж нийт 1,240 хүүхдийг хамруулан 439,372.5 мянган төгрөгөөр санхүүжүүлсэн.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нэгдсэн үндэстний байгууллагын /НҮБ/ Хөгжлийн хөтөлбөрөөс Монгол Улсад 2023-2027 онд хэрэгжүүлэх “Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ” санамж бичгийн дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газарт Нэгдсэн үндэстний байгууллагын /НҮБ/ Хүүхдийн сангаас 298,258.2 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Хүүхэд хамгааллын тухай хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр батлагдсан ба хуулийг олон нийтэд сурталчилан таниулах арга хэмжээ зохион байгуулах, түүнийг даган гарах журам, стандарт боловсруулах зардалд нийт 225,788.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		19,216,659.7	29,520,842.3
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	14,612,193.0	24,615,395.6
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	897,153.4	610,689.2
УРЬДЧИЛГАА	7а, 7б	85,115.8	75,074.7
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	3,622,197.5	4,219,682.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		62,587,688.3	74,575,583.2
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	62,587,688.3	74,575,583.2
Биет хөрөнгө		58,707,611.0	70,774,371.7
Биет бус хөрөнгө	13	3,880,077.4	3,801,211.5
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		81,804,348.0	104,096,425.5
НИЙТ ӨР ТӨЛБӨР		303,938.4	205,073.8
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	303,938.4	205,073.8
Өглөг	17а, 17б	285,979.8	205,073.8
Урьдчилж орсон орлого	18а, 18б	17,958.5	-
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		81,500,409.7	103,891,351.7
Засгийн газрын хувь оролцоо		81,500,409.7	103,891,351.7
Хуримтлагдсан үр дүн		35,431,071.0	58,237,314.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		23,833,957.1	23,418,656.1
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		81,804,348.0	104,096,425.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		65,909,523.0	97,136,624.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	15,975,882.8	33,507,457.8
Нийтлэг татварын бус орлого		15,975,882.8	33,507,457.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		49,933,640.2	63,629,166.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	58,441,243.3	71,908,015.8
УРСГАЛ ЗАРДАЛ		58,441,243.3	71,908,015.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		55,336,139.2	66,079,003.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		19,359,397.2	28,131,675.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,436,242.1	3,457,386.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		3,632,437.8	3,861,750.2
Хангамж, бараа материалын зардал		1,786,596.5	2,390,034.3
Нормативд зардал		2,828,272.1	3,945,113.1
Эд хогшил, урсгал засварын зардал		559,816.5	578,065.9
Томилолт, зочны зардал		199,523.3	146,717.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		18,067,433.4	16,726,750.1
Бараа үйлчилгээний бусад зардал		6,466,420.3	6,841,510.5

УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,105,104.1	5,829,012.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		7,468,279.6	25,228,609.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		623.7	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		1,015,075.7	2,830,954.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		6,453,827.6	22,397,654.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	60,052,358.9	80,859,022.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,276,858.6	16,716,015.9
Нийтлэг татварын бус орлого	9,276,858.6	16,716,015.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	50,775,500.3	64,143,007.0
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	54,205,232.2	68,592,650.4
УРСГАЛ ЗАРДАЛ	54,205,232.2	68,592,650.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,491,840.1	62,384,358.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,350,873.3	28,134,183.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,445,343.3	3,414,627.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,741,522.4	3,883,202.8
Хангамж, бараа материалын зардал	956,383.2	1,101,158.2
Нормативд зардал	2,975,863.2	3,997,249.7
Эд хогшил, урсгал засварын зардал	652,569.6	938,081.0
Томилолт, зочны зардал	196,043.7	131,587.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,329,566.2	18,404,614.1
Бараа үйлчилгээний бусад зардал	1,843,675.4	2,379,653.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,713,392.1	6,208,292.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,847,126.7	12,266,372.4
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,082,005.4	2,263,169.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,082,005.4	2,263,169.8
Дотоод эх үүсвэрээр	1,082,005.4	2,263,169.8
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,082,005.4)	(2,263,169.8)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	4,765,121.3	10,003,202.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,847,071.6	14,612,193.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,612,193.0	24,615,395.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	74,530,196.2	-	74,530,196.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	500,811.5	-	500,811.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	75,031,007.8	-	75,031,007.8
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(955.7)	-	(955.7)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	16,530.0	-	16,530.0
Тайлант үеийн үр дүн	6,453,827.6	-	6,453,827.6
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	81,500,409.7	-	81,500,409.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	408,589.0	-	408,589.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	81,908,998.7	-	81,908,998.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(415,301.1)	-	(415,301.1)
Тайлант үеийн үр дүн	22,397,654.1	-	22,397,654.1
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	103,891,351.7	-	103,891,351.7

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	71,163,552,200.00	57,565,016,859.44	13,598,535,340.56	80.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	71,163,552,200.00	57,565,016,859.44	13,598,535,340.56	80.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,369,191,900.00	56,186,572,574.64	4,182,619,325.36	93.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,142,793,800.00	26,011,158,185.04	2,131,635,614.96	92.4
210101	Үндсэн цалин	15,300,073,000.00	14,330,735,819.12	969,337,180.88	93.7
210102	Нэмэгдэл	9,250,741,600.00	6,829,162,080.05	2,421,579,519.95	73.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,621,407,500.00	3,056,412,179.11	(1,435,004,679.11)	188.5
210104	Урамшуулал	1,970,571,700.00	1,792,295,436.76	178,276,263.24	91.0
210105	Гэрээт ажлын хөлс	-	2,552,670.00	(2,552,670.00)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,496,049,400.00	3,195,818,585.48	300,230,814.52	91.4
210201	Тэтгэврийн даатгал	2,375,629,800.00	2,178,624,954.05	197,004,845.95	91.7
210202	Тэтгэмжийн даатгал	280,216,300.00	261,236,082.88	18,980,217.12	93.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	151,307,300.00	142,215,028.99	9,092,271.01	94.0
210204	Ажилгүйдлийн даатгал	128,909,200.00	113,708,221.54	15,200,978.46	88.2
210205	Эрүүл мэндийн даатгал	559,986,800.00	500,034,298.02	59,952,501.98	89.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,177,950,300.00	3,848,741,073.34	329,209,226.66	92.1
210301	Гэрэл, цахилгаан	683,644,100.00	584,460,750.55	99,183,349.45	85.5
210302	Түлш, халаалт	2,744,968,200.00	2,586,061,786.00	158,906,414.00	94.2
210303	Цэвэр, бохир ус	466,487,600.00	409,053,384.79	57,434,215.21	87.7
210304	Байрны түрээс	282,850,400.00	269,165,152.00	13,685,248.00	95.2
2104	Хангамж, бараа материалын зардал	868,273,400.00	861,252,370.50	7,021,029.50	99.2
210401	Бичиг хэрэг	140,072,000.00	140,465,405.00	(393,405.00)	100.3
210402	Тээвэр, шатахуун	305,528,000.00	300,432,531.00	5,095,469.00	98.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,442,000.00	75,940,657.50	(498,657.50)	100.7
210404	Ном, хэвлэл	25,372,600.00	23,523,300.00	1,849,300.00	92.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	39,500,200.00	36,323,288.00	3,176,912.00	92.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	282,358,600.00	284,567,189.00	(2,208,589.00)	100.8
2105	Нормативд зардал	3,672,696,700.00	3,660,981,127.35	11,715,572.65	99.7
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,059,400.00	22,689,076.35	(629,676.35)	102.9
210502	Хоол, хүнс	3,122,824,900.00	3,117,978,351.00	4,846,549.00	99.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	527,812,400.00	520,313,700.00	7,498,700.00	98.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,544,577,700.00	1,540,267,990.10	4,309,709.90	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	788,768,700.00	787,181,125.60	1,587,574.40	99.8
210602	Тавилга	5,542,600.00	5,514,800.00	27,800.00	99.5
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,739,700.00	1,729,300.00	2,010,400.00	46.2
210604	Урсгал засвар	746,526,700.00	745,842,764.50	683,935.50	99.9

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2107	Томилолт, зочны зардал	24,827,500.00	22,080,300.00	2,747,200.00	88.9
210702	Дотоод албан томилолт	24,827,500.00	22,080,300.00	2,747,200.00	88.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,981,906,700.00	16,591,081,893.40	1,390,824,806.60	92.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,730,986,900.00	16,354,906,454.06	1,376,080,445.94	92.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	19,302,800.00	16,783,700.00	2,519,100.00	86.9
210803	Даатгалын үйлчилгээ	10,132,000.00	8,786,254.00	1,345,746.00	86.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	30,962,800.00	29,554,398.95	1,408,401.05	95.5
210805	Тээврийн хэрэгслийн оношилогоо	2,365,700.00	1,551,850.00	813,850.00	65.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	169,325,200.00	165,027,914.39	4,297,285.61	97.5
210807	Газрын төлбөр	17,981,800.00	13,623,642.00	4,358,158.00	75.8
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	849,500.00	847,680.00	1,820.00	99.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	460,116,400.00	455,191,049.43	4,925,350.57	98.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	298,115,700.00	297,967,182.43	148,517.57	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	162,000,700.00	157,223,867.00	4,776,833.00	97.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,794,360,300.00	1,378,444,284.80	9,415,916,015.20	12.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,794,360,300.00	1,378,444,284.80	9,415,916,015.20	12.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,500,000,000.00	260,709,700.00	9,239,290,300.00	2.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	352,675,600.00	238,242,275.50	114,433,324.50	67.6
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	766,761,300.00	713,379,009.30	53,382,290.70	93.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	174,923,400.00	166,113,300.00	8,810,100.00	95.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	71,163,552,200.00	67,396,471,325.24	3,767,080,874.76	94.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	55,152,856,500.00	50,689,978,809.06	4,462,877,690.94	91.9
310001	Улсын төсвөөс санхүүжих	55,152,856,500.00	50,689,978,809.06	4,462,877,690.94	91.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	16,010,695,700.00	16,706,492,516.18	(695,796,816.18)	104.3
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,331,689,100.00	16,501,123,521.18	(10,169,434,421.18)	260.6
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	179,006,600.00	205,368,995.00	(26,362,395.00)	114.7
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	9,500,000,000.00	-	9,500,000,000.00	-

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	14,509,160,026.25	(14,509,160,026.25)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	24,340,564,992.05	(24,340,564,992.05)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,261	2,203	58	97.4
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	37	37	-	100.0
610001	Төсвийн байгууллага	37	37	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	1,112	1,083	29	97.4
620001	Удирдах ажилтан	39	38	1	97.4
620002	Гүйцэтгэх ажилтан	812	790	22	97.3
620003	Үйлчлэх ажилтан	261	255	6.00	97.7

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Т3 цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	12,666,295,615.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	12,531,014,657.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	11,891,338,816.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	2,123,025,648.53
210101	Үндсэн цалин	-	887,610,721.65
210102	Нэмэгдэл	-	861,239,219.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	105,286,984.00
210104	Урамшуулал	-	197,224,635.40
210105	Гэрээт ажлын хөлс	-	71,664,088.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	218,809,093.76
210201	Тэтгэврийн даатгал	-	163,051,766.85
210202	Тэтгэмжийн даатгал	-	15,092,440.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	8,099,429.89
210204	Ажилгүйдлийн даатгал	-	6,121,034.27
210205	Эрүүл мэндийн даатгал	-	26,444,422.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	115,332,417.36
210301	Гэрэл, цахилгаан	-	16,403,062.59
210302	Түлш, халаалт	-	55,807,373.38
210303	Цэвэр, бохир ус	-	18,881,981.39
210304	Байрны түрээс	-	24,240,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	246,322,462.26
210401	Бичиг хэрэг	-	52,167,600.00
210402	Тээвэр, шатахуун	-	54,962,190.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	15,655,265.26
210404	Ном, хэвлэл	-	17,872,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	6,633,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	99,031,307.00
2105	Нормативд зардал	-	517,449,929.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	8,308,850.00
210502	Хоол, хүнс	-	431,231,299.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	77,909,780.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	472,040,353.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	154,567,981.00
210602	Тавилга	-	96,091,930.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	400,000.00
210604	Урсгал засвар	-	220,980,442.00
2107	Томилолт, зочны зардал	-	109,507,450.00

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210701	Гадаад албан томилолт	-	12,104,900.00
210702	Дотоод албан томилолт	-	97,402,550.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	5,958,769,254.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	5,948,329,852.17
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,209,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	78,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	197,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	8,409,900.00
210807	Газрын төлбөр	-	522,552.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,130,082,208.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,976,206,401.07
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	153,875,807.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	639,675,841.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	105,331,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	105,331,400.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	534,344,441.56
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	528,477,579.09
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,866,862.47
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	135,280,958.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	135,280,958.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	135,280,958.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	12,666,295,615.91
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	12,666,295,615.91
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	352,628,102.70
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,435,437,143.73
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	6,972,885,853.42
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,905,344,516.06
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төвлөрүүлэн захирагч болон харьяа 38 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 33 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдаж дүгнэлт гаргасан 33 байгууллагын 24 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 7 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” дүгнэлт өгч 1 байгууллагад дүгнэлт гаргахаас татгалзсан байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 29,301.8 сая төгрөгийн 54 зөрчил илэрснээс, 16,273.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 14 албан шаардлагыг хүргүүлж, 12,856.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 39 зөвлөмж, 162.4 сая төгрөгийн хариуцлага тооцуулах 1 албан шаардлага өгсөн. Үүнээс төсвийн төвлөрүүлэн захирагчид Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой албан шаардлага хүргүүлсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагч:

Илрүүлэлт: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 10 байгууллагад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 16,549.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс 5 байгууллагад зөрчил давтагдан гарсан нь Мэдээллийн технологи, хяналт, шинжилгээ, үнэлгээний газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.3-т "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан:", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр:", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1-д "Төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх:", 15 дугаар зүйлийн 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх:", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй хугацаа хоцруулсан, зөрчлийг давтан гаргасан, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох арга хэмжээг авч, зөрчлийг арилгаж, дахин давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 34,834.4 сая төгрөгийн 68 алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 7,480.3 сая

төгрөгийн 134 зөрчил илэрснээс 99.8 сая төгрөгийн зөрчилд 30 төлбөрийн акт тогтоож, 2,847.4 сая төгрөгийн зөрчилд 52 албан шаардлага хүргүүлэн, 4,533.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 52 зөвлөмжийг өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 7,480.3 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 6,768.7 сая төгрөгөөр их тул **“Хязгаарлалттай”** дүгнэлт өглөө.

Төсвийн төвлөрүүлэн захирагч:

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 2,476.7 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 22.5 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 857.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 албан шаардлагыг хүргүүлж, 1,597.2 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

3.1 Албан шаардлага

1. Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн гүйцэтгэлийг 0.01 сая төгрөгөөр зөрүүтэй, харьяа байгууллагын хооронд шилжүүлсэн 3.3 сая төгрөгийн хөрөнгийн устгалыг хийгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд төсвийн гүйцэтгэл, үр дүнгийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Харьяа байгууллагууд түлш халаалтын зардлаас 80.9 сая төгрөгийн, бичиг хэргийн зардлаас 0.8 сая төгрөгийн, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас 5.6 сая төгрөгийн, хоол, хүнсний зардлаас 161.4 сая төгрөгийн, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас 19.8 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний хураамжийн зардлаас 541.2 сая төгрөгийн, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 21.1 сая төгрөг, нийт 830.8 сая төгрөгийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах"; Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу эдийн засгийн ангилалд нийцүүлэн зарцуулаагүй зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэв.

3. Өнөр бүл хүүхдийн төв нь Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газарт бүртгэлтэй 4 нэр төрлийн 11 ширхэг 22.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээр үнэ төлбөргүй шилжүүлэн авч үндсэн хөрөнгө дансанд орлогоор бүртгэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна.", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1-д "Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТӨБЗГ-ын газрын хөрөнгө шилжүүлэх шийдвэргүй 22.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4.Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 37 байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 39,837.9 сая төгрөгийн 194 алдаа зөрчил илэрснээс 34,811.8 сая төгрөгийн 66 алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 5,026.1 сая төгрөгийн 128 зөрчил, 19 байгууллагад нийцлийн аудиттай холбоотой 12,752.8 сая төгрөгийн 42 зөрчил илэрсэн нь төсвийн төвлөрүүлэн захирагчаас санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-т "хариуцлагатай байх", 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх;", 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;", 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй, алдаа зөрчлийг 20-оос доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлоготой холбоотой асуудал:

Илрүүлэлт 1. Харьяа зарим байгууллагууд үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө батлуулаагүй нэмэлт санхүүжилтийн дансанд 1,573.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-д "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:, 41.2.1.хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөн батлуулах, гүйцэтгэлийг хангуулж ажиллах.

2. Авлагын дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт 2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар харьяа 3 байгууллагын нийт 24.2 сая төгрөгийн олон жилийн насжилттай авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ аваагүй.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн "6.4.8 -д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг үр ашигтай, зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

4.1. Аудитаар нийт 34,834.4 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар ТТЗ	1	22,486.0	1	14,056.0	1	8,430.0	2	22,486.0	-	-
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар ТШЗ	4	75,979.8	2	27,299.8	2	48,680.0	4	75,979.8	-	-
Өнөр бүл хүүхдийн төв	3	10,096,438.5	1	9,902,191.9	2	194,246.6	3	10,096,438.5	-	-
Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор	6	3,536,011.2	-	-	6	3,536,011.2	6	3,536,011.2	-	-
Говь-Алтай аймгийн ХГБХХГ	7	79,621.3	2	44,480.1	5	35,141.2	7	79,621.3	-	-
Говьсүмбэр аймгийн ХГБХХГ	2	6,358.3	-	-	2	6,358.3	2	6,358.3	-	-
Дархан-Уул аймгийн ХГБХХГ	1	709.7	-	-	1	709.7	1	709.7	-	-
Дорноговь аймгийн ХГБХХГ	1	13,038.6	-	-	1	13,038.6	1	13,038.6	-	-
Дорнод аймгийн ХГБХХГ	1	22,182.6	-	-	1	22,182.6	1	22,182.6	-	-
Орхон аймгийн ХГБХХГ	2	28,249.0	1	144.0	1	28,105.0	2	28,249.0	-	-
Өмнөговь аймгийн ХГБХХГ	3	21,070.6	-	-	3	21,070.6	3	21,070.6	-	-
Увс аймгийн ХГБХХГ	2	25,760.9	1	472.1	1	25,288.8	2	25,760.9	-	-
Ховд аймгийн ХГБХХГ	1	2,380.0	-	-	1	2,380.0	1	2,380.0	-	-
Хөвсгөл аймгийн ХГБХХГ	2	75,641.1	-	-	2	75,641.1	2	75,641.1	-	-
Хэнтий аймгийн ХГБХХГ	1	10,890.0	1	10,890.0	-	-	1	10,890.0	-	-
Нийслэлийн ХГБХХГ	3	205,301.9	-	-	3	205,301.9	3	205,301.9	-	-
Чингэлтэй дүүргийн ХГБХХХ	4	236,057.1	1	25,014.0	3	211,043.1	4	236,057.1	-	-
Сүхбаатар дүүргийн ХГБХХХ	2	101,599.4	-	-	2	101,599.4	2	101,599.4	-	-
Хан-Уул дүүргийн ХГБХХХ	7	1,897,637.4	1	20,000.0	6	1,877,637.4	7	1,897,637.4	-	-
Баянгол дүүргийн ХГБХХХ	4	75,373.6	1	250.0	3	75,123.6	4	75,373.6	-	-
Баянзүрх дүүргийн ХГБХХХ	2	581,755.2	-	-	2	581,755.2	2	581,755.2	-	-
Багануур дүүргийн ХГБХХХ	2	6,264.7	-	-	2	6,264.7	2	6,264.7	-	-
Багахангай дүүргийн ХГБХХХ	2	13,377.2	-	-	2	13,377.2	2	13,377.2	-	-
Хүүхдийн төлөө сан	4	17,700,186.0	-	-	4	17,700,186.0	4	17,700,186.0	-	-
Дүн	68	34,834,370.1	12	10,044,797.9	56	24,789,572.2	68	34,834,370.1	-	-

ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

4.2. Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 7,480.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 99,826.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2,847.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлж, 4,533.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар ТТЗ	6	2,454,225.5	-	-	4	857,028.0	2	1,597,197.5	-	-
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар ТШЗ	21	2,608,322.5	3	25,212.4	8	723,816.7	10	1,859,293.4	-	-
Хүүхдийн төлөө сан	1	-	-	-	-	-	1	-	-	-
Өнөр бүл хүүхдийн төв	8	125,240.9	3	13,698.3	2	7,113.4	3	104,429.2	-	-
Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор	9	123,365.3	-	-	2	107,418.2	7	15,947.1	-	-
Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв	3	104,571.9	-	-	1	13,433.4	2	91,138.5	-	-
Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр	2	242,182.1	-	-	2	242,182.1	-	-	-	-
Архангай аймгийн ХГБХХГ	2	4,609.3	1	2,852.3	1	1,757.0	-	-	-	-
Баян-Өлгий аймгийн ХГБХХГ	1	2,910.0	1	2,910.0	-	-	-	-	-	-
Булган аймгийн ХГБХХГ	2	12,808.9	1	10,908.9	-	-	1	1,900.0	-	-
Говь-Алтай аймгийн ХГБХХГ	4	6,865.3	4	6,865.3	-	-	-	-	-	-
Говьсүмбэр аймгийн ХГБХХГ	3	8,571.9	1	2,206.5	1	5,799.0	1	566.4	-	-
Дархан-Уул аймгийн ХГБХХГ	1	373.0	1	373.0	-	-	-	-	-	-
Дорнод аймгийн ХГБХХГ	4	3,385.9	4	3,385.9	-	-	-	-	-	-
Дундговь аймгийн	2	1,986.0	1	315.0	1	1,671.0	-	-	-	-
Сүхбаатар аймгийн ХГБХХГ	1	2,727.5	-	-	1	2,727.5	-	-	-	-
Орхон аймгийн ХГБХХГ	5	12,919.1	-	-	3	12,919.1	2	-	-	-
Өмнөговь аймгийн ХГБХХГ	3	45,237.0	0	-	3	45,237.0	-	-	-	-
Сэлэнгэ аймгийн ХГБХХГ	5	22,850.3	1	300.0	3	8,784.2	1	13,766.1	-	-
Увс аймгийн ХГБХХГ	1	4,248.9	1	4,248.9	-	-	-	-	-	-
Ховд аймгийн ХГБХХГ	3	321,536.3	1	4,462.1	-	-	2	317,074.2	-	-
Хөвсгөл аймгийн ХГБХХГ	2	968.9	-	-	-	-	2	968.9	-	-
Өвөрхангай аймгийн ХГБХХГ	1	2,171.6	-	-	1	2,171.6	-	-	-	-
Хэнтий аймгийн ХГБХХГ	3	8,000.1	2	1,453.4	1	6,546.7	-	-	-	-

ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Нийслэлийн ХГБХХГ	5	110,065.1	2	6,677.6	2	19,900.0	1	83,487.5	-	-
Налайх дүүргийн ХГБХХХ	3	93,803.5	-	-	2	84,263.5	1	9,540.0	-	-
Сонгинохайрхан дүүргийн ХГБХХХ	3	35,042.0	-	-	1	20,042.0	2	15,000.0	-	-
Чингэлтэй дүүргийн ХГБХХХ	5	367,661.6	0	-	3	360,225.0	2	7,436.6	-	-
Сүхбаатар дүүргийн ХГБХХХ	2	7,353.5	1	3,700.0	-	-	1	3,653.5	-	-
Хан-Уул дүүргийн ХГБХХХ	9	323,474.4	1	9,000.0	4	204,946.9	4	109,527.5	-	-
Баянгол дүүргийн ХГБХХХ	4	30,688.7	-	-	2	24,720.0	2	5,968.7	-	-
Баянзүрх дүүргийн ХГБХХХ	8	385,072.1	1	1,257.1	4	94,730.0	3	289,085.0	-	-
Багануур дүүргийн ХГБХХХ	1	3,070.0	-	-	-	-	1	3,070.0	-	-
Багахангай дүүргийн ХГБХХХ	1	3,995.3	-	-	-	-	1	3,995.3	-	-
Дүн	134	7,480,304.5	30	99,826.7	52	2,847,432.4	52	4,533,045.4	-	-

4.3.Нийцлийн аудиттай холбоотой нийт 29,301.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 16,273.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 162.4 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, 12,856.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар ТТЗ	1	-	-	-	1	-	-	-	-	-
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар ТШЗ	1	14,352,833.8	-	-	1	14,352,833.8	-	-	-	-
Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор	1	548,596.7	-	-	1	548,596.7	-	-	-	-
Дархан-Уул аймгийн ХГБХХГ	1	384,410.1	-	-	-	-	1	384,410.1	-	-
Өвөрхангай аймгийн ХГБХХГ	1	829.0	-	-	1	829.0	-	-	-	-
Чингэлтэй дүүргийн ХГБХХХ	2	-	-	-	-	-	2	-	-	-
Сүхбаатар дүүргийн ХГБХХХ	1	-	-	-	-	-	1	-	-	-
Хан-Уул дүүргийн ХГБХХХ	1	1,236,425.1	-	-	1	1,236,425.1	-	-	-	-

**ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

Баянгол дүүргийн ХГБХХХ	1	-	-	-	-	-	1	-	-	-
Багануур дүүргийн ХГБХХХ	1	8,916.8	-	-	1	8,916.8	-	-	-	-
Багахангай дүүргийн ХГБХХХ	1	17,062.1	-	-	1	17,062.1	-	-	-	-
Дүн	12	16,549,073.6	-	-	7	16,164,663.5	5	384,410.1	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Хүүхдийн төлөө сан	1	10,092,114.7	-	-	-	-	1	10,092,114.7	-	-
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар ТШЗ	1	5,565.0	-	-	-	-	1	5,565.0	-	-
Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор	1	11,150.4	-	-	1	11,150.4	-	-	-	-
Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв	1	20,490.5	-	-	1	20,490.5	-	-	-	-
Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр	5	196,108.4	-	-	2	33,658.4	2	-	1	162,450.0
Баян-Өлгий аймгийн ХГБХХГ	1	49,358.0	-	-	-	-	1	49,358.0	-	-
Булган аймгийн ХГБХХГ	1	21,220.0	-	-	1	21,220.0	-	-	-	-
Говьсүмбэр аймгийн ХГБХХГ	1	13,384.9	-	-	1	13,384.9	-	-	-	-
Дархан-Уул аймгийн ХГБХХГ	1	36,000.0	-	-	-	-	1	36,000.0	-	-
Нийслэлийн ХГБХХГ	3	413,778.1	-	-	-	-	3	413,778.1	-	-
Налайх дүүргийн ХГБХХХ	3	220,340.0	-	-	-	-	3	220,340.0	-	-
Сонгинохайрхан дүүргийн ХГБХХХ	3	390,601.8	-	-	-	-	3	390,601.8	-	-
Чингэлтэй дүүргийн ХГБХХХ	2	197,428.5	-	-	-	-	2	197,428.5	-	-
Сүхбаатар дүүргийн ХГБХХХ	3	309,482.6	-	-	1	9,223.5	2	300,259.1	-	-
Хан-Уул дүүргийн ХГБХХХ	3	140,019.3	-	-	-	-	3	140,019.3	-	-
Баянгол дүүргийн ХГБХХХ	3	212,948.9	-	-	-	-	3	212,948.9	-	-
Баянзүрх дүүргийн ХГБХХХ	3	316,602.4	-	-	-	-	3	316,602.4	-	-
Багануур дүүргийн ХГБХХХ	3	71,355.8	-	-	-	-	3	71,355.8	-	-
Багахангай дүүргийн ХГБХХХ	3	34,825.1	-	-	-	-	3	34,825.1	-	-
Дүн	42	12,752,774.4	-	-	7	109,127.8	34	12,481,196.7	1.0	162,450.0
Нийт дүн	54	29,301,848.0	-	-	14	16,273,791.3	39	12,865,606.8	1.0	162,450.0